



**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

┌ Байгууллагын Дотоод хяналт, шалгалтын ┐
комиссын бүрэлдэхүүнийг баталж, хяналт,
шалгалтыг зохион байгуулах журамд
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын Дотоод хяналт, шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга

Гишүүд

Хуулийн зөвлөх

Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн
Маркетинг, олон нийтийн харилцаа, хот
хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журмын 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, 4 дэх хэсэг, 4 дэх хэсгийн 4.2, 4.4, 4.5 дахь заалтад тус тус өөрчлөлтийг оруулж хавсралтаар батлан нийт албан хаагчдад танилцуулахыг Дотоод хяналт, шалгалтын комисс (С.Отгонбаатар)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/22 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

Багануур үйлдвэрлэл, технологийн парк
ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны
өдрийн А/04 дүгээр тушаалын хавсралт



БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын Дотоод хяналт шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг даргын тушаалаар томилно.

1.3. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын Дотоод хяналт шалгалтын комисс нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт нийтлэг журам болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын комиссын чиглэл

2.1. Дотоод хяналт шалгалтын комисс нь байгууллагын үйл ажиллагаа нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, дээд газраас ирсэн албан даалгавар болон Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

Гурав. Дотоод хяналт шалгалтын комиссын эрх үүрэг

3.1. Дотоод хяналт шалгалтын комиссын дарга нь байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил, ажлын дадлага туршлагатай байна.

3.2. Дотоод хяналт шалгалтын комисс нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, зохион байгуулалтын бүтэц, нэгжийн тоог харгалзан тухайн жилд хийх дотоод хяналт шалгалтын тусгай төлөвлөгөө боловсруулж Газрын даргаар батлуулан мөрдөж ажиллана.

3.3. Дотоод хяналт шалгалтын комисс нь хяналт шалгалтын удирдамж гаргаж даргаар батлуулж, удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг улирал бүр гүйцэтгэнэ.

3.4. Дотоод хяналт шалгалтын комисс нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэг удаа байгууллагын удирдлагад танилцуулж, шаардлагатай бол удирдлагаас шийдвэр гаргуулж хамт олонд танилцуулна.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын комиссын нийтлэг эрх, үүрэг

4.1. Байгууллагын албан хаагчдын ажлын байрны чиг үүргийн дагуу хариуцсан ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах

4.2. Дотоод хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

4.3. Шаардлагатай тохиолдолд зөрчил, дутагдлын шалгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал дэвшүүлэх

4.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг байгууллагын албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хангах, шаардлагатай тохиолдолд холбогдох эрх зүйн актыг сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах

4.5. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй бүхий л дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох судалгаа хийж дүгнэлт гаргаж танилцуулах

4.6. Тухайн жилд хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтлөх

Тав. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

5.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт

5.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд тавих хяналт шалгалт

5.3. Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт

5.4. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

5.5. Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан бусад хяналт шалгалт

Зургаа. Хариуцлага

6.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

6.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.